

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2013 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2013.10.23

Улаанбаатар хот


НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 2 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 1 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 5 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2013 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 143 хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ХЗХ-дын тооны өөрчлөлтийг сүүлийн 8 жилийн байдлаар харуулбал:



Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын гишүүдийн тооны өөрчлөлтийг харуулбал:



Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Санхүүгийн зохицуулах хороо

Онууд	шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	ХЗХ-дын тоо
2006	51	0	0	-	-	51
2007	128	0	0	-	-	179
2008	45	15	5	-	-	209
2009	15	12	8	1	25	212
2010	2	35	15	4	80	179
2011	4	21	9	-	47	162
2012	3	17	7	4	26	148
2013-3	2	7	1	-	49	143

Нийт ХЗХ-дын 95.8 хувь буюу 137 ХЗХ-ноос 2013 оны гуравдугаар улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан ирүүлсэн, харин 4.2 хувь буюу 6 ХЗХ нь тайлан мэдээг ямар нэг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Хороонд ирүүлээгүй байна.

2013 оны гуравдугаар улирлын байдлаар санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан мэдээгээ ирүүлээгүй 6 ХЗХ-ны нэгтгэлд хамруулсан үеийн буюу хамгийн сүүлд Хороонд ирүүлсэн санхүүгийн тайланг хугацааны хувьд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Тайлангийн хугацаа	ХЗХ-ны тоо	ХЗХ-дын нэрс
1	2012- I улирлаар	1	Увс аймгийн Хяргас хас
2	2013- I улирлаар	1	Өвөрхангай аймгийн Найдвартай хөгжил
3	2013- II улирлаар	4	Увс аймгийн Наранхас булаг, Завхан аймгийн Нугын дэвшил, Улаанбаатар хотын Гэрэг инвест, Ховд аймгийн Дөргөн хөгжил,
Нийт		6	

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД**2.1 Ерөнхий статистик үзүүлэлтүүд**

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ*	/тоогоор/ НИЙТ
Нийт гишүүдийн тоо	26 052
Үүнээс: эмэгтэй	12 178
Гишүүдийн насжилт	
18-35 насны	5 685
36-45 насны	7 739
46-55 насны	5 779
55-аас дээш	3 298
Гишүүдийн боловсрол	
Дээд	8 685
Тусгай дунд	3 712
Бүрэн дунд	4 983
Дунд	3 133
Бага	1 401
Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо	
Хугацаатай	6 384
Хугацаагүй	1 915
Зээлдэгч гишүүдийн тоо	9 532
Хэвийн	10 066
Хугацаа хэтэрсэн	466
Чанаргүй:	524
Хэвийн бус	180
Эргэлзээтэй	109
Муу	235

*-Статистик мэдээллийг 2013 оны гуравдугаар улирлаас зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангийн хамт цахим хэлбэрээр хүлээн авч эхэлсэн.

2.2 Ерөнхий санхүүгийн үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны III улирал	2013 оны III улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	151	143	(8)	-5.3
2	Гишүүдийн тоо	26 368	26 052	(316)	-1.2
3	Нийт актив	65,450,973.4	71,180,662.1	5,729,688.7	8.8
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0,6%</i>	<i>0,4%</i>	<i>(0,2)</i>	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	50,795,691.8	55,313,190.7	4,517,498.9	8.9
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0,7%</i>	<i>0,5%</i>	<i>(0,2)</i>	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,658,971.9	1,696,045.0	37,073.1	2.2
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0,5%</i>	<i>0,3%</i>	<i>(0,2)</i>	
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	45,993,358.9	48,154,006.7	2,160,647.8	4.7
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>1,1%</i>	<i>0,9%</i>	<i>(0,2)</i>	
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	8,920,341.4	9,680,575.0	760,233.6	8.5
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>30,0%</i>	<i>*</i>		
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	6,234,151.2	8,037,717.9	1,803,566.7	28.9
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	1,301,735.5	1,205,712.4	(96,023.0)	-7.4
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	382,200.5	620,608.7	238,408.2	62.4
11	Нийт орлого	12,029,514.2	12,774,078.4	744,564.2	6.2
12	Нийт зардал	8,901,347.9	9,781,885.4	880,537.5	9.9
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	3,128,166.3	2,992,193.1	(135,973.2)	-4.3

Тайлант улиралд ХЗХ-дод Банк болон ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн үлдэгдэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 2 ХЗХ-нд 985,000.0 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 13 ХЗХ-нд 220,712.4 мянган төгрөг, салбарын хэмжээнд нийт 15 ХЗХ-нд 1,205,712.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 96,023.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 143 ХЗХ-д байгаагийн 41.3 хувь буюу 59 ХЗХ нь Улаанбаатар хотод, 58.7 хувь буюу 84 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. 2013 оны гуравдугаар улирлын байдлаар 143 ХЗХ-дын орон нутгийн байршлыг үзүүлбэл:



2.3 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны III улирал	2013 оны III улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	66	59	(7)	-10,6
2	Гишүүдийн тоо	11 500	11 169	(331)	-2,9
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	43,7%	42,9%	-0,8%	
3	Нийт актив	56,536,174.9	60,935,206.5	4,399, 031.6	7,8
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	86,4%	85,6%	-0,8%	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	44,090,916.4	47,594,305.5	3,503,389.1	7,9
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	86,8%	86,0%	-0,8%	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,413,048.5	1,520,130.2	107,081.8	7,6
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	85,2%	89,6%	4,4%	
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	41,990,320.6	43,380,229.2	1,389,908.2	3,3
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	91,3%	90,1%	-1,2%	
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	6,136,117.3	6,778,519.7	642,402.4	10,5
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	68,8%	70,0%	1,2%	
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	5,036,623.9	6,681,912.6	1,645,288.7	32,7
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	80,8%	83,1%	2,3%	
9	Нийт банк, ББСБ-аас авсан БХ-Т зээлийн дүн	955,892.0	985,000.0	29,108.0	3,0
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	130,870.1	57,629.2	-73,240.9	-56,0
11	Нийт орлого	9,968,612.1	10,493,388.2	524,776.1	5,3
12	Нийт зардал	7,523,284.6	8,126,455.9	603,171.3	8,0
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	2,445,327.5	2,366,932.3	-78,395.2	-3,2

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 59 ХЗХ-дын нийт актив 60,935,206.5 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 85.6 хувийг, орлого 10,493,388.2 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлогын 82.1 хувийг, зардал 8,126,455.9 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт зардлын 83.1 хувийг тус тус эзэлж байна.

2.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны III улирал	2013 оны III улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	85	84	(1)	-1.2
2	Гишүүдийн тоо	14,868	14,883	15	0.1
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	56,3%	57,1%	0,8%	
3	Нийт актив	8,914,798.5	10,245,455.6	1,330,657.1	14.9
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	13,6%	14,4%	0,8%	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	6,704,775.4	7,718,885.2	1,014,109.8	15.1
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	13,2%	14,0%	0,8%	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	245,923.4	175,914.7	-70,008.7	-28.5
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	14,8%	10,4%	-4,4%	
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	4,003,038.3	4,773,777.5	770,739.2	19.3
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	8,7%	9,9%	1,2%	
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	2,784,224.1	2,902,055.3	117,831.2	4.2
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	31,2%	30,0%	-1,2%	

Санхүүгийн зохицуулах хороо

8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	1,197,527.3	1,355,805.3	158,278.0	13.2
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	19,2%	16,9%	-2,3%	
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	345,843.5	220,712.4	-125,131.1	-36.2
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	251,330.4	562,979.5	311,649.1	124.0
11	Нийт орлого	2,060,902.1	2,280,690.3	219,788.2	10.7
12	Нийт зардал	1,378,063.3	1,655,429.5	277,366.2	20.1
13	Тухайн үеийн ашиг	682,838.8	625,260.8	-57,578.1	-8.4

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 84 ХЗХ-дын актив 10,245,455.6 мянган төгрөг байгаа нь нийт активын 14.4 хувийг, орлого 2,280,690.3 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлогын 17.9 хувийг, зардал 1,655,429.5 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт зардлын 16.9 хувийг тус тус эзэлж байна.

2.5 Хасбанкны франчайзын гэрээтэй ажиллаж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны III улирал	2013 оны III улирал	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт	
				дүн	хувь
1	Хас банктай франчайзийн гэрээтэй ХЗХ-дын тоо	49	49	-	
2	Гишүүдийн тоо	9 785	10 210	425	4.3
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	37,1%	39,2%	2,1%	
3	Нийт актив	4,587,293.3	5,418,578.8	831,285.5	18,1
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	7,0%	7,6%	0,6%	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	3,663,320.1	4,271,632.6	608,312.5	16,6
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	7,2%	7,7%	0,5%	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	149,028.2	74,479.7	-74,548.5	-50,0
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	9,0%	4,4%	-4,6%	
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	1,534,911.7	2,029,252.0	494,340.3	32,2
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	3,3%	4,2%	0,9%	
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,732,226.5	1,747,255.0	15,028.5	0,9
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	19,4%	18,0%	-1,4%	
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	679,440.3	771,348.9	91,908.6	13,5
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	10,9%	9,6%	-1,3%	
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	301,700.1	212,161.9	-89,538.2	-29,7
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	183,926.7	474,135.5	290,208.8	157,8
11	Нийт орлого	1,045,558.6	1,199,877.0	154,318.4	14,8
12	Нийт зардал	692,347.9	851,744.0	159,396.1	23,0
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	353,210.7	348,132.9	-5,077.8	-1,4

ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Активын чанар

ХЗХ-дын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2012/09/30		2013/09/30		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	64 007 903,3	97,8	69 430 809,7	97,5	5 422 906,4	8,5
МӨНГӨН ХӨРӨНГӨ	11 233 033,8	17,2	12 047 186,7	16,9	814 152,8	7,2
Касс дахь бэлэн мөнгө	2 167 914,8	3,3	2 282 886,6	3,2	114 971,9	5,3
Банкинд байршуулсан харилцах	6 619 146,7	10,1	6 532 078,2	9,2	(87 068,5)	-1,3
Банкинд байршуулсан хадгаламж	2 445 972,4	3,7	3 232 221,9	4,5	786 249,4	32,1
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	49 699 177,5	75,9	54 396 999,0	76,4	4 697 821,5	9,5
Нийт зээл	50 795 691,8	77,6	55 313 190,7	77,7	4 517 498,9	8,9
Хэвийн зээл	48 171 964,3	73,6	52 557 544,3	73,8	4 385 580,1	9,1
Хугацаа хэтэрсэн зээл	964 755,6	1,5	1 059 601,4	1,5	94 845,8	9,8
Чанаргүй зээл	1 658 971,9	2,5	1 696 045,0	2,4	37 073,1	2,2
<i>Хэвийн бус</i>	568 884,7	0,9	702 159,1	1,0	133 274,4	23,4
<i>Эргэлзээтэй зээл</i>	347 714,8	0,5	653 385,3	0,9	305 670,5	87,9
<i>Муу зээл</i>	742 372,4	1,1	340 500,5	0,5	(401 871,8)	-54,1
(Зээлийн эрсдэлийн сан)	1 096 514,3	1,7	916 191,7	1,3	(180 322,6)	-16,4
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2 442 137,8	3,7	2 347 847,1	3,3	(94 290,7)	-3,9
Байгууллага, хүмүүсээс авах авлага	299 353,3	0,5	218 091,77	0,3	(81 261,6)	-27,1
(Байгууллага, хүмүүсээс авах авлагүй эрсдлийн сан)	30 344,6	0,0		0,0	(30 344,6)	-100,0
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2 173 129,1	3,3	2 129 755,35	3,0	(43 373,7)	-2,0
БУСАД ХӨРӨНГӨ	199 725,1	0,3	92 853,7	0,1	(106 871,5)	-53,5
Материал үнэ бүхий зүйл	124 625,4	0,2	61 119,4	0,1	(63 506,0)	-51,0
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	28 032,1	0,0	31 734,2	0,0	3 702,1	13,2
Бусад актив	47 067,6	0,1	0,0	0,0	(47 067,6)	-100,0
ӨБУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	433 829,0	0,7	545 923,3	0,8	112 094,3	25,8
Өмчлөх бусад хөрөнгө	462 965,4	0,7	549 079,5	0,8	86 114,2	18,6
(Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан)	29 136,4	0,0	3 156,2	0,0	(25 980,1)	-89,2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1 443 070,1	2,2	1 749 852,4	2,5	306 782,2	21,3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1 393 299,5	2,1	1 697 913,0	2,4	304 613,6	21,9
Үндсэн хөрөнгө	1 843 827,6	2,8	2 170 056,4	3,0	326 228,8	17,7
(Үндсэн хөрөнгийн элэгдэл)	450 528,2	0,7	472 143,4	0,7	21 615,2	4,8
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	49 770,7	0,1	51 939,3	0,1	2 168,7	4,4
Биет бус хөрөнгө	19 714,3	0,0	8 848,3	0,0	(10 866,0)	-55,1
Бусад	30 056,4	0,0	43 091,0	0,1	13 034,7	43,4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	65 450 973,4	100,0	71 180 662,1	100,0	5 729 688,7	8,8

Активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.8 хувиар буюу 5,729,688.7 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.9 хувиар буюу 4,517,498.9 мянган төгрөгөөр, банкинд байршуулсан хадгаламж 32.1 хувиар буюу 786,249.4 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг графикаар харуулбал:



Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Активын хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт актив	Нийт активт эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	1	31 044 923,5	43,6%
2	1,000,000.0-10,000,000.0	9	24 458 919,5	34,4%
3	500,000.0-1,000,000.0	4	3 005 558,1	4,2%
4	100,000.0-500,000.0	43	9 594 611,0	13,5%
5	50,000.0-100,000.0	23	1 622 964,1	2,3%
6	10,000.0-50,000.0	49	1 367 358,9	1,9%
7	5,000.0-10,000.0	10	73 930,8	0,1%
8	5,000.0 хүртэл	4	12 396,1	0,0%
Нийт дүн		143	71 180 662,1	100,0%

ХЗХ-ны активын төвлөрлийг ангилгахад томоохон буюу 1 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 10 ХЗХ-ны нийт актив 55,503,843.1 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 78.0 хувийг эзэлж байна.

3.2 Зээлийн үйл ажиллагааны талаар

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2012/09/30	хувь	2013/09/30	хувь	Өөрчлөлт	
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	49 699 177,5		54 396 999,0		4 697 821,5	9,5%
Нийт зээл	50 795 691,8	100,0%	55 313 190,7	100,0%	4 517 498,9	8,9%
Хэвийн зээл	48 171 964,3	94,8%	52 557 544,3	95,0%	4 385 580,1	9,1%
Хугацаа хэтэрсэн зээл	964 755,6	1,9%	1 059 601,4	1,9%	94 845,8	9,8%
Чанаргүй зээл	1 658 971,9	3,3%	1 696 045,0	3,1%	37 073,1	2,2%
<i>Хэвийн бус</i>	568 884,7	1,1%	702 159,1	1,3%	133 274,4	23,4%
<i>Эргэлзээтэй зээл</i>	347 714,8	0,7%	653 385,3	1,2%	305 670,5	87,9%
<i>Муу зээл</i>	742 372,4	1,5%	340 500,5	0,6%	-401 871,8	-54,1%
(Зээлийн эрсдэлийн сан)	1 096 514,3		916 191,7		-180 322,6	-16,4%

Тайлант улирлын байдлаар ХЗХ-дын нийт зээлийн багц 55,313,190.7 мянган төгрөг байгаа нь активын 77.7 хувьтай тэнцэж байна. Цэвэр зээлийн өрийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,697,821.5 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн бол, чанаргүй зээлийн үлдэгдэл 37,073.1 мянган төгрөгөөр өсч, зээлийн чанар 2.2 хувиар буурсан үзүүлэлтүүдтэй байна.

Санхүүгийн зохицуулах хороо

Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,517,498.9 мянган төгрөгөөр, зээлийн болзошгүй эрсдэлийн сан 180,322.6 мянган төгрөгөөр тус тус буурч зээлийн багцын чанар сайжирсан байна.

ХЗХ-дын зээлийн өрийн үлдэгдлийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.

д/д	Зээлийн хэмжээ /интервал/	ХЗХ-дын тоо	Нийт зээлийн хэмжээ	Нийт зээлд эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	1	24 680 178,4	44,6%
2	1,000,000.0-10,000,000.0	7	17 056 668,6	30,8%
3	500,000.0-1,000,000.0	5	3 482 718,1	6,3%
4	100,000.0-500,000.0	34	7 000 438,5	12,7%
5	50,000.0-100,000.0	24	1 774 897,7	3,2%
6	10,000.0-50,000.0	49	1 187 506,0	2,1%
7	5,000.0-10,000.0	11	89 524,9	0,2%
8	5,000.0 хүртэл	12	41 258,5	0,1%
	Нийт дүн	143	55 313 190,7	100,0%

Зээлийн өрийн үлдэгдлийг бүлэглэхэд 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй 13 ХЗХ-ны зээлийн өрийн үлдэгдэл 45,219,565.1 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын зээлийн өрийн үлдэгдлийн 81.8 хувийг эзэлж байна.

**ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

4.1 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ нийт активын 67.7 хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийг бүлэглэн харуулбал:

д/д	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	1	23 006 899,2	47,8%
2	1,000,000.0-10,000,000.0	4	14 513 090,0	30,1%
3	500,000.0-1,000,000.0	7	4 878 174,5	10,1%
4	100,000.0-500,000.0	19	3 578 686,7	7,4%
5	50,000.0-100,000.0	16	1 051 332,6	2,2%
6	10,000.0-50,000.0	41	988 544,9	2,1%
7	5,000.0-10,000.0	11	80 192,0	0,2%
8	5,000.0 хүртэл	29	57 086,7	0,1%
9	Хадгаламжгүй	15		0,0%
	Нийт хадгаламжийн дүн	143	48 154 006,7	100,0%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 12 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 42,398,163.8 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 88.0 хувийг эзэлж байна.

Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж татан төвлөрүүлээгүй 15 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 10.5 хувийг эзэлж байгаа ба эдгээр нь зөвхөн өөрийн хөрөнгөөрөө үйл ажиллагаагаа явуулж байна.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг графикаар харуулбал:



4.2 Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн талаар

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2012/09/30		2013/09/30		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Дүн	Хувь	Дүн
ӨР ТӨЛБӨР	50 296 480,8	76,8	53 462 369,2	75,1	3 165 888,4	6,3
ХАДГАЛАМЖ	45 993 358,9	70,3	48 154 006,7	67,7	2 160 647,8	4,7
Хугацаагүй	2 987 112,6	4,6	1 712 104,6	2,4	-1 275 008,0	-42,7
Хугацаатай	43 006 246,3	65,7	46 441 902,0	65,2	3 435 655,8	8,0
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	1 301 735,5	2,0	1 205 712,4	1,7	-96 023,0	-7,4
Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	1 266 888,7	1,9	1 165 712,4	1,6	-101 176,3	-8,0
Богино хугацаат төслийн санхүүжилт	34 846,7	0,1	40 000,0	0,1	5 153,3	0,1
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2 619 186,0	4,0	3 488 836,7	4,9	869 650,8	33,2
Татварын төлөх өглөг	98 556,3	0,2	119 823,8	0,2	21 267,6	21,6
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2 399 330,1	3,7	2 907 897,2	4,1	508 567,2	21,2
Өглөг	74 520,4	0,1	429 605,7	0,6	355 085,3	476,5
Бусад пассив	46 779,2	0,1	31 510,0	0,0	-15 269,2	-32,6
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	382 200,5	0,6	613 813,3	0,9	231 612,9	60,6
Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	237 530,4	0,4	585 498,1	0,8	347 967,7	146,5
Урт хугацаат төслийн санхүүжилт	144 670,1	0,2	28 315,2	0,0	-116 354,9	0,0
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	15 154 492,6	23,2	17 718 292,9	24,9	2 563 800,3	16,9
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	8 920 341,4	13,6	9 680 575,0	13,6	760 233,6	8,5
Хувь нийлүүлсэн хөрөнгө	8 920 341,4	13,6	9 680 575,0	13,6	760 233,6	8,5
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	6 234 151,2	9,5	8 037 717,9	11,3	1 803 566,7	28,9
Нөөцийн сан	2 082 662,9	3,2	2 209 730,4	3,1	127 067,5	6,1
Дахин үнэлгээний сан	223 591,0	0,3	346 167,1	0,5	122 576,1	54,8
Нийгмийн хөгжлийн сан	322 504,6	0,5	383 332,6	0,5	60 827,9	18,9
Бусад сангууд	166 770,3	0,3	476 294,9	0,7	309 524,6	185,6
Хандив, тусламж	44 314,8	0,1	52 760,1	0,1	8 445,3	19,1
Хадгаламж хамгаалалтын сан			8 542,6			
Бусад өмч	36 771,3	0,1		0,0	-36 771,3	-100,0
Тайлангийн үеийн ашиг/алдагдал	3 128 166,3	4,8	2 992 193,1	4,2	-135 973,2	-4,3
Хуримтлагдсан ашиг/алдагдал	229 370,1	0,4	1 568 697,2	2,2	1 339 327,1	583,9
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	65 450 973,4	100,0	71 180 662,1	100,0	5 729 688,7	8,8

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,729,688.7 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд хадгаламжийн хэмжээ

Санхүүгийн зохицуулах хороо

2,160,647.8 мянган төгрөгөөр, хувь хөрөнгө 760,233.6 мянган төгрөгөөр, хоршоологчдын өмч 1,808,566.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

4.3 Хувь хөрөнгийн талаар

Тайлант улирлын байдлаар хувь хөрөнгийн хэмжээ 9,680,575.0 мянган төгрөг байгаа нь нийт активын 13.6 хувийг эзэлж байна. Үүнийг интервалаар харуулбал:

д/д	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь
1	2,000,000.0 дээш	1	2 062 124,4	21,3%
2	500,000.0-1,000,000.0	2	1 675 526,2	17,3%
3	100,000.0-500,000.0	15	2 547 346,1	26,3%
4	50,000.0-100,000.0	24	1 660 918,1	17,2%
5	15,000.0-50,000.0	49	1 367 624,6	14,1%
6	10,000.0-15,000.0	12	140 095,3	1,4%
7	5,000.0-10,000.0	24	177 878,0	1,8%
8	5,000.0 хүртэл	16	49 062,2	0,5%
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	143	9 680 575,0	100,0%

ХЗХ-дын хувь хөрөнгийн өсөлт дараах байдалтай байна.



4.4 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2013 оны гуравдугаар улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 2,563,800.3 мянган төгрөгөөр өсч 17,718,292.9 мянган төгрөгт хүрсэн. Үүнийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.

д/д	Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын нэр	Өөрийн хөрөнгийн дүн	Нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь
1	2,000,000.0 дээш	1	5 219 919,9	29,5%
2	500,000.0-1,000,000.0	5	4 400 698,6	24,8%
3	100,000.0-500,000.0	21	4 289 505,9	24,2%
4	50,000.0-100,000.0	29	2 023 643,0	11,4%
5	10,000.0-50,000.0	59	1 606 043,2	9,1%
6	1,000.0-10,000.0	28	181 574,7	1,0%
	Нийт өөрийн хөрөнгийн дүн	143	17 721 385,2	100,0%

Санхүүгийн зохицуулах хороо

Өр төлбөрийн хэмжээ нь активаас хэтэрсэн буюу өрийн хөрөнгөгүй болсон ХЗХ байхгүй. ХЗХ-дын хоршоологчдын өмчийн байдлыг интервалаар харуулбал:

/мянган төгрөгөөр/				
д/д	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь
1	500,000.0 дээш	2	3 672 102,8	45,7%
2	100,000.0-500,000.0	11	2 617 776,9	32,6%
3	50,000.0-100,000.0	11	680 973,4	8,5%
4	15,000.0-50,000.0	30	814 543,9	10,1%
5	10,000.0-15,000.0	12	143 389,1	1,8%
6	1,000.0-10,000.0	55	250 240,2	3,1%
7	1,000.0 хүртэл	9	3 802,6	0,0%
8	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	13	-145 111,0	-1,8%
Нийт дүн		143	8 037 717,9	100,0%

Алдагдалтай ажилласнаас хоршоологчдын өмчгүй болсон 13 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/					
№	ХЗХ-ны нэр	Хоршоологчдын өмчийн дүн	№	ХЗХ-ны нэр	Хоршоологчдын өмчийн дүн
1	Грави	(73 448,2)	8	Гүүдлайф	(3 046,7)
2	Мон инвест	(23 649,3)	9	Нугын дэвшил	(1 326,1)
3	Баяжмалсан	(16 726,0)	10	Бизнесийн оргил	(943,6)
4	Финстар	(8 465,5)	11	Жамба нинж	(706,1)
5	ТДМ	(6 422,2)	12	Хамтын хөгжлийн чуулган	(206,8)
6	Дархан түрүү	(6 020,5)	13	Наран хас булаг	(83,0)
7	Алдиар	(4 067,0)			

ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

5.1 ХЗХ-дын орлогын үзүүлэлтүүд

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	/мянган төгрөгөөр/					
	2012/09/30		2013/09/30		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
ХҮҮГИЙН ОРЛОГО	11 107 331,1	92,3	12 383 042,0	96,9	1 275 710,9	11,5
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	10 709 538,7	89,0	11 975 194,0	93,7	1 265 655,3	11,8
Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	137 901,8	1,1	127 438,0	1,0	-10 463,8	-7,6
Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	234 795,7	2,0	279 951,7	2,2	45 156,0	19,2
Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	3 037,8	0,0	458,3	0,0	-2 579,5	-84,9
Бусад хүүгийн орлого	22 057,1	0,2		0,0	-22 057,1	-100,0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	605 616,3	5,0	190 150,3	1,5	-415 466,0	-68,6
Элсэлтийн хураамж	7 356,2	0,1	12 650,2	0,1	5 294,0	72,0
Гишүүний татвар	21 231,5	0,2	18 625,5	0,1	- 2 606,0	-12,3
Үйлчилгээний хураамж	115 261,7	1,0	133 955,7	1,0	18 694,0	16,2
Үйл ажиллагааны бусад орлого	461 766,9	3,8	24 918,8	0,2	-436 848,0	-94,6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	316 566,8	2,6	200 886,2	1,6	-115 680,6	-36,5

Санхүүгийн зохицуулах хороо

Торгуулийн орлого	4 342,6	0,0	34,3	0,0	-4 308,3	-99,2
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	38 696,0	0,3	7 176,2	0,1	-31 519,8	-81,5
ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	1 700,0	0,0	2 753,8	0,0	1 053,8	-
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	19 809,7	0,2		0,0	-19 809,7	-100,0
Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	46 011,7	0,4		0,0	-46 011,7	-100,0
Бусад орлого	126 432,9	1,1	190 922,0	1,5	64 489,1	51,0
Онцгой шинжтэй орлого	79 526,5	0,7		0,0	-79 526,5	-100,0
Ердийн бус орлого	47,4	0,0		0,0	-47,4	
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	12 029 514,2	100,0	12 774 078,4	100,0	744 564,2	6,2

2013 оны гуравдугаар улиралд ХЗХ-дын нийт орлого 12,774,078.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 744,564.2 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн. Энэ нь зээлийн хүүгийн орлого 1,275,710.9 мянган төгрөгөөр өсч, үйл ажиллаганы бусад орлого 415,466.0 мянган төгрөгөөр, үйл ажиллаганы бус орлого 115,680.6 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

5.2 ХЗХ-дын зардлын үзүүлэлтүүд

Зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2012/09/30		2013/09/30		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
ХҮҮГИЙН ЗАРДАЛ	6 113 685,5	68,7	6 575 652,2	67,2	461 966,8	7,6
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	3 162 072,7	35,5	6 360 093,7	65,0	3 198 021,0	101,1
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх)	2 401 594,2	27,0		0,0	-2 401 594,2	-100,0
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жил)	425 675,5	4,8		0,0	-425 675,5	-100,0
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	107 735,6	1,2	215 064,0	2,2	107 328,5	99,6
Бусад хүүгийн зардал	16 607,4	0,2	494,5	0,0	-16 112,9	-97,0
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	239 392,6	2,7	415 796,6	4,3	176 403,9	73,7
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	223 169,4	2,5	412 338,8	4,2	189 169,4	84,8
Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	7 253,8	0,1		0,0	-7 253,8	-100,0
Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	5 562,4	0,1	3 457,7	0,0	-2 104,7	-37,8
Бусад эрсдэлийн зардал	3 406,9	0,0		0,0	-3 406,9	-100,0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2 127 620,2	23,9	2 416 983,9	24,7	289 363,7	13,6
Боловсон хүчний зардал	1 397 259,5	15,7	1 638 448,5	16,7	241 189,1	17,3
Бусад зардал	730 360,8	8,2	778 535,4	8,0	48 174,6	6,6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	420 649,6	4,7	373 452,7	3,8	-47 196,9	-11,2
Торгуулийн зардал	10 825,7	0,1	4 116,7	0,0	-6 709,0	-62,0
Ногдол ашгийн зардал	300,0	0,0		0,0	-300,0	
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	2 199,6	0,0		0,0	-2 199,6	-100,0
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	27 206,4	0,3	834,6	0,0	-26 371,8	-96,9
Үйл ажиллагааны бус бусад зардал	30 335,9	0,3	37 028,0	0,4	6 692,2	22,1
Ердийн бус зардал	10 075,4	0,1		0,0	-10 075,4	-100,0
Татварын зардал	339 706,6	3,8	331 473,3	3,4	-8 233,2	-2,4
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	8 901 347,9	100,0	9 781 885,4	100,0	880 537,5	9,9

Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 9,781,885.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 880,537.5 мянган төгрөгөөр буюу 9.9 хувиар өсчээ. Үүнд хадгаламжийн хүүгийн зардал 461,966.8 мянган төгрөгөөр, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 176,403.9 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 289,363.7 мянган төгрөгөөр тус тус өссөн, харин үйл ажиллагааны бус зардал 47,196.9 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлтүүд нөлөөлсөн байна.

5.3 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-д

Нийт 143 ХЗХ-дын 9.8 хувь буюу 14 ХЗХ тайлант улиралд 77,379.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/				
д/д	Алдагдлын хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
1	5,000.0 мянган төгрөгөөс дээш	6	(67 401,4)	87,1%
2	1,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэл	5	(8 820,6)	11,4%
3	500.0-1,000.0 мянган төгрөг хүртэл	1	(928,7)	1,2%
4	100.0-500.0 мянган төгрөг хүртэл	1	(143,0)	0,2%
5	100.0 мянган төгрөг хүртэл	1	(85,8)	0,1%
Нийт дүн		14	(77 379,5)	100,0%

ХЗХ-дын нийт активт эзлэх алдагдлын түвшин 0.1 хувь байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 51,752.2 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Алдагдалтай ажиллаж байгаа ХЗХ-дын 9 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ба тэдгээрийн алдагдлын хэмжээ 58,183.9 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт алдагдлын 75.2 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 5 ХЗХ тайлант улиралд 19,195.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь ХЗХ-дын нийт алдагдлын 24.8 хувийг эзэлж байна. Үүний дотор Хасбанктай франчайзын гэрээтэй 2 ХЗХ-ны 1,632.3 мянган төгрөгийн алдагдал нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан ХЗХ-дын алдагдлын 8.5 хувийг, ХЗХ-дын нийт алдагдлын 2.1 хувийг тус тус эзэлж байна.

5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-д

Салбарын хэмжээнд тайлант улирлын байдлаар 3,069,572.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба ашгийн түвшин 4.2 хувь байгаа хэдий ч өмнөх оны мөн үеэс 84,221.1 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

/мянган төгрөгөөр/				
д/д	Ашгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь
1	100,000.0 мянган төгрөгөөс дээш	4	1 661 677,3	54,1%
2	50,000.0-100,000.0 мянган төгрөг хүртэл	6	547 855,1	17,8%
3	10,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл	28	649 779,8	21,2%
4	5,000.0-10,000.0 мянган төгрөг хүртэл	14	96 999,9	3,2%
5	1,000.0-5,000 мянган төгрөг хүртэл	39	97 971,4	3,2%
6	1,000.0 мянган төгрөг хүртэл	38	15 289,1	0,5%
Нийт дүн		129	3 069 572,5	100,0%

Санхүүгийн зохицуулах хороо

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 50 ХЗХ тайлант улиралд 2,420,513.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь ХЗХ-дын нийт ашгийн 78.9 хувийг эзэлж байна.

Харин орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 79 ХЗХ тайлант улиралд 649,059.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь ХЗХ-дын нийт ашгийн 21.1 хувийг, Хасбанктай франчайзын гэрээтэй 47 ХЗХ нийт 349,765.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан ХЗХ-дын нийт ашгийн 53.9 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРГАА. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭСЭН ТАЛААР

Хорооноос ХЗХ-дод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй ХЗХ-дыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор активын хэмжээгээр нь 4 ангилж бүлэглэвэл:

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах ХЗХ-н тоо	ХЗХ-нд эзлэх хувь	Нийт активт эзлэх хувь	Үүнээс	
					УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо
Бүлэг-1	50.0 сая төгрөг хүртэл	63	44.1%	2.0%	23	40
Бүлэг-2	50-500.0 сая төгрөг	66	46.2%	15.8%	25	41
Бүлэг-3	500.0-1.0 тэрбум төгрөг	4	2.7%	4.2%	2	2
Бүлэг-4	1.0 тэрбумаас дээш	10	7.0%	78.0%	9	1
	Нийт дүн	143	100.0%	100.0%	59	84

ДОЛОО. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдаж, 2012 оны 62, 2013 оны 79 дүгээр тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт орсон “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР
А	АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН		
1	АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/	895,713.0	916,191.7
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	5.00%-иас бага	2.4%
3	ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	30.00%--иас бага	Тооцох боломжгүй
4	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30.00%--иас бага	Тооцох боломжгүй
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ		
5	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ	60%-80% хүртэл	77.7%
6	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5.00% -иас бага	0.8%
7	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10.00%-иас бага	2.4%
8	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	80.00%-иас бага	67.7%
9	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20.00%-иас бага	2.6%
10	ГИШҮҮДИЙН НИЙТ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5.00%-иас их	13.5%
11	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ	10.00%-иас бага	Тооцох

	ХАРЬЦАА		боломжгүй
12	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ /мянган төгрөг/	1,205,657.7	2,209,730.4
В	ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ		
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН	15.00%-иас бага	3.4%
Г	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР		
14	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	5.00%-иас их	10.8%
Д	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)		
15	АКТИВЫН ӨГӨӨЖ		4.2%

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна. Тайлант улирлын байдлаар Хорооноос журмаар тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 17 ХЗХ бүрэн хангаж ажилласан, 120 ХЗХ 1-4 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, 6 ХЗХ 5-7 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй үзүүлэлттэй байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2013 оны гуравдугаар улирлын байдлаар 143 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байгаа нь 2012 оны мөн үетэй харьцуулахад тооны хувьд 8-аар буурсан хэдий ч санхүүгийн болон үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд тодорхой хэмжээний өсөлтүүд гарч чанарын ахицтай байна. Тухайлбал:

1. Нийт актив

Нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,729,688.7 мянган төгрөгөөр буюу 8.8 хувиар өсөж, банкны салбарын 0,4 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд дундаж активын хэмжээ 1,032,800.1 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж ХЗХ-ны дундаж активын хэмжээ 121,969.7 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-ны хувьд 176,191.4 мянган төгрөгөөр, орон нутгийн ХЗХ-ны хувьд 17,089.7 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2. Нийт зээлийн өрийн үлдэгдэл

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 5,517,498.9 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өсөж, банкны салбарын 0.5 хувийг эзэлж байна. Чанаргүй зээлийн өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 37,073.1 мянган төгрөг буюу 2.2 хувиар өссөн байна. Тайлант улиралд муу зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 401,871.8 мянган төгрөгөөр, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 180,322.6 мянган төгрөгөөр тус тус буурсан сайн үзүүлэлттэй байна.

3. Татан төвлөрүүлсэн хадгаламж

ХЗХ-дын хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2,160,647.8 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өсөж, банкны салбарын 0.9 хувийг эзэлж байна. Нийт мөнгөн хадгаламжийн 96.4 хувь нь хугацаатай, 3.6 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

4. Хувь хөрөнгийн хэмжээ

Хувь хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 760,233.6 мянган төгрөгөөр өссөн байна.

5. Хоршоологчдын өмч

Хоршоологчдын өмчийн хэмжээ өмнөх оны мөн үеийн байдлаас 1,803,566.7 мянган төгрөгөөр өссөн. Хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн нь бусдын өмнө

ХЗХ-дын хүлээх үүрэг хариуцлага өндөржиж, өөрийн хөрөнгийн чадавхи дээшилсэн эерэг үзүүлэлт гэж дүгнэж байна.

6. Нийт орлого, ашиг

ХЗХ-дын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 744,564.2 мянган төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 880,537.5 мянган төгрөгөөр тус тус өсч 2013 оны гуравдугаар улирлын байдлаар тайлант үеийн ашиг 2,992,193.1 мянган төгрөг байна. Тайлант үеийн ашгийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 135,973.2 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-доос 2012 оны зохицуулалтын үйлчилгээний хөлс 14,020.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс 2013 оны гуравдугаар улирлын байдлаар 14,000.3 мянган төгрөг буюу 99.6 хувийг төсөвт төвлөрүүлсэн ба төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээний нэмэлт зөвшөөрөл олгосон 2 ХЗХ, шинээр тусгай зөвшөөрөл олгосон 2 ХЗХ-ноос нэг удаа төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс болох 600.0 мянган төгрөгийг төвлөрүүлж нийт 14,600.3 мянган төгрөг төлөгдсөн байна.

Аудитын тухай хуулиар ХЗХ-д нь санхүүгийн жилийн эцсийн тайлангаа баталгаажуулах үүрэгтэй. 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 145 хоршоо аудитын байгууллагаар баталгаажуулан ирүүлэхээс 97.2 хувь буюу 141 ХЗХ аудитын дүгнэлт, аудитлагдсан тайлангаа ирүүлээд байна.

Мөн “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” хуульд заасан хугацаанд хийсэн Бүх гишүүдийн ээлжит хурлын тэмдэглэл, шийдвэрийг 145 хоршоо ирүүлэх ёстойгоос гуравдугаар улирлын байдлаар 138 ХЗХ-ноос холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 95.2 хувьтай байна.

Гуравдугаар улирлын байдлаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох үүргээ хэрэгжүүлэн хамтран ажиллах гэрээ байгуулсан 39 ХЗХ байна. Орон нутагт үйл ажиллагаа ХЗХ-д байнгын интернет байхгүй, Монголбанкнаас тавьж буй техникийн шаардлагыг хангах боломжгүй байгаагаас хуулийн хэрэгжилт муу байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих ажилтан томилж, холбогдох баримт бичгээ Хороонд ирүүлсэн 95 ХЗХ буюу хуулийн хэрэгжилт 66.4 хувийн биелэлттэй байна.

Тус хэлтсийн хянан шалгагчид 2013 оны гуравдугаар улирлын байдлаар Хорооны даргын баталсан 7 удаагийн тушаалаар нэр бүхий 29 ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж 10 ХЗХ-нд УБАШ-аар хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулсан, 7 ХЗХ-ны удирдлагуудад зөрчлийн тэмдэглэл үйлдэн захиргааны арга хэмжээ авч 5,615.0 мянган төгрөгийн торгууль оногдуулж 5,193.8 мянган төгрөгийн торгуулийн мөнгийг төсөвт төвлөрүүлсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 92.5 хувьтай байна.

Цаашид “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллах, орон нутгийн хоршоодод газар дээрх үзлэг, шалгалтыг хийж бодит нөхцөл байдалд дүгнэлт өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ХЭЛТЭС